



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/087/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаанбаатар хот  
2025 он

Санхүүгийн аудитын газрын захирал,  
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)

Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: [natsagdorjs@audit.gov.mn](mailto:natsagdorjs@audit.gov.mn)

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул  
Утас: 261740 Цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Гэрээгээр гүйцэтгэсэн Гроут финанс Аудит ХХК-ийн  
Захирал: Б.Бямба  
Утас: 99094391 Цахим хаяг: [byambaa@growthfinance.mn](mailto:byambaa@growthfinance.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,  
Цахим шуудан: info@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ  
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Б.ДҮГЭРЖАВ ТАНАА

2025.03.31 № 07/1342  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тавантолгой төмөр зам ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Сөрөг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулаагүй байна.

### Сөрөг санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 77,045.3 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархсан байна. Тухайлбал:

- Монголын төмөр зам ТӨХК-аас авах 1,218.5 сая төгрөгийн алданги, Улаанбаатар төмөр зам ХНН-ээс авах 3.5 сая төгрөгийн алданги, нийт 1,222.0 сая төгрөгийн гэрээний алдангийн төлбөрийг барагдуулаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Дарханы төмөрлөгийн үйлдвэр ТӨХК болон Монголросцветмет ТӨҮГ-т төлбөртэй түрээслүүлж байсан 250 вагоны гэрээг Зам тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан бичгийн дагуу цуцалж, Улаанбаатар төмөр зам ХНН-д үнэ төлбөргүй ашиглуулсан;
- Харилцагч байгууллагуудаас авах 768.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэл тулган баталгаажуулах захидлаар нотлогдоогүй;
- Компанийн хөдөлмөрийн дотоод журмыг зөрчин, сахилгын шийтгэлтэй 50 ажилтанд Гүйцэтгэх захирлын тушаалаар 290.3 сая төгрөгийн урамшуулалт цалин олгосон;

- Газар эзэмших эрхүүдийг нийт дүнгээр бүртгэснийг талбар нэгж бүрээр бүртгэх өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, хувьцаа эзэмшигчээс хөрөнгө оруулсан 7,400.6 сая төгрөгийн өртөг бүхий газар эзэмших эрх хүчингүй болж, улсын бүртгэлийн лавлагаагаар баталгаажуулаагүй;
- Бүртгэлд тусгаагүй төслөөс хүлээн авсан хөрөнгийг бусдад түрээслүүлж орлого олж байгаа ч түүнтэй холбоотой зардал бүртгээгүй, мөн элэгдлийн зардал бүртгээд байгаа хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулж байгаа ч орлогыг хүлээн зөвшөөрөөгүй
- Засгийн газрын 2022 оны 459 дүгээр тогтоолын дагуу Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд зарцуулсан хөрөнгөнд хөндлөнгийн аудит хийлгэж, дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэсний дагуу Грант торнтон аудит ХХК-аас зөвлөх үйлчилгээ авч, зөвлөхийн тайланг хүлээн авсан ч Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороогоор хэлэлцэж шийдвэр гаргаагүйгээс төслийн гүйцэтгэл болон хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2, 27 дугаар зүйлийн 27.1, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.3, 81.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.5 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх, хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг баталсан байна.

Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганц модны боомтын хил дамнасан гүүрийг хамтран барих төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу техник, эдийн засгийн үндэслэл, нарийвчилсан зураг төслийг боловсруулж, 16,299.5 сая төгрөгөөр магадласан байна.

Тус төсөл нь Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дэвсгэрт Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын үргэлжлэл бөгөөд өргөн царигийн 8.7 км, нарийн царигийн 10.8 км төмөр зам баригдаж, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай төмөр замаар холбогдох хоёр дахь гарц болж байна.

### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд 135,825.8 сая төгрөгийн борлуулсан бүтээгдэхүүний өртөг тооцож төлөвлөснөөс 50.6 хувиар дутуу байгаа нь төслөөс хүлээн авсан үндсэн хөрөнгүүдийг нягтлан бодох бүртгэлд тусгаагүйгээс үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал байгуулахгүй байгаа нь голлон нөлөөлсөн байна.

Тайланд онд 4 байгууллагаас авах тээвэр, түрээсийн төлбөрийн 1,108.3 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлсэн байна.

## Бусад мэдээлэл

Аудиторын тайланд тусгах асуудлын талаар аудиторын зүгээс Төлөөлөн удирдах зөвлөлтэй ярилцсанаар аудитор нэмэлт тодруулга авах боломж үүсдэг, энэ удаа хүсэлт гаргасан ч тайлбар авч чадаагүй болно. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	69,980,171,532.25	39,434,750,644.07
1.1.2	Дансны авлага	7,640,780,763.58	17,146,580,280.04
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	179,879,526,123.04	200,523,531,664.38
1.1.4	Бусад авлага	3,367,892,980.85	6,649,354,476.38
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	17,648,365,774.68	73,925,649,809.06
1.1.6	Бараа материал	1,116,456,943.89	4,196,419,687.70
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,478,399,073,976.38	1,515,035,333,525.14
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,758,032,268,094.6</b>	<b>1,856,911,620,086.77</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	142,376,136,535.74	140,560,328,715.93
1.2.2	Биет бус хөрөнгө	230,602,316,045.89	230,566,551,659.77
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2,223,391,729,729.91	2,293,590,464,907.63
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,596,370,182,311.54</b>	<b>2,664,717,345,283.33</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,354,402,450,406.21</b>	<b>4,521,628,965,370.10</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1</b>	<b>Өр төлбөр</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	408,281,720,868.64	445,051,557,379.51
2.1.1.2	Цалингийн өглөг	1,336,890,811.46	600,167.86
2.1.1.3	Татварын өр	444,799,954.36	5,743,115,220.12
2.1.1.5	Урьдчилж орсон орлого	18,981,640,178.75	21,858,131,589.91
2.1.1.6	Бусад богино хугацаат өр төлбөр	20,231,777,275.59	24,181,691,170.65
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>449,276,829,088.80</b>	<b>496,835,095,528.06</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Хойшлогдсон татварын өр	1,032,415,607.20	1,336,052,948.24
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,032,415,607.20</b>	<b>1,336,052,948.24</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>450,309,244,696.00</b>	<b>498,171,148,476.29</b>
<b>2.3</b>	<b>Эздийн өмч</b>		
2.3.1	Өмч:-төрийн	2,040,479,750,000.00	2,040,479,750,000.00
2.3.2	Эздийн өмчийн бусад хэсэг	1,858,936,268,852.87	1,937,106,372,907.65
2.3.3	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4,677,186,857.34	45,871,693,986.16
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>3,904,093,205,710.21</b>	<b>4,023,457,816,893.81</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,354,402,450,406.21</b>	<b>4,521,628,965,370.10</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого	31,207,609,931.24	95,144,528,068.06
2	Борлуулалтын өртөг	36,351,842,956.23	67,056,077,124.56
3	<b>Нийт ашиг( алдагдал)</b>	<b>(5,144,233,024.99)</b>	<b>28,088,450,943.50</b>
4	Түрээсийн орлого	7,014,728,181.81	22,117,899,012.70
5	Хүүний орлого	3,472,953,765.68	8,896,839,704.37
6	Бусад орлого	1,161,874,750.14	1,375,086,070.78
7	Ерөнхий ба удирдлагын зардал	862,713,874.95	10,293,769,582.41
8	Бусад зардал	22,419,990.40	15,289,250.00
9	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>5,620,189,807.29</b>	<b>50,169,216,898.94</b>
10	Орлогын татварын зардал	1,197,191,347.66	10,311,600,581.58
11	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>4,422,998,459.63</b>	<b>39,857,616,317.36</b>
12	<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
13	<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>4,422,998,459.63</b>	<b>39,857,616,317.36</b>
14	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
15	<b>Орлогын нийт дүн</b>	<b>4,422,998,459.63</b>	<b>39,857,616,317.36</b>
16	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)</b>	<b>5.42</b>	<b>48.83</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>659,125,216,436.83</b>	<b>329,210,633.88</b>	<b>2,699,934,177,070.71</b>
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(75,022,236.16)	(75,022,236.16)
3	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>659,125,216,436.83</b>	<b>254,188,397.71</b>	<b>2,699,859,154,834.54</b>
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	4,422,998,459.63	4,422,998,459.63
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	1,199,811,052,416.04	-	1,199,811,052,416.04
6	<b>2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>1,858,936,268,852.87</b>	<b>4,677,186,857.34</b>	<b>3,904,093,205,710.21</b>
7	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	1,336,890,811.46	1,336,890,811.46
8	<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>1,858,936,268,852.87</b>	<b>6,014,077,668.80</b>	<b>3,905,430,096,521.67</b>
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	39,857,616,317.36	39,857,616,317.36
10	Өмчид гарсан өөрчлөлт	-	78,170,104,054.78	-	78,170,104,054.78
11	<b>2024 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл</b>	<b>2,040,479,750,000.00</b>	<b>1,937,106,372,907.65</b>	<b>45,871,693,986.16</b>	<b>4,023,457,816,893.81</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөр-ийн №	ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>62,264,560,353.11</b>	<b>171,428,270,490.72</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	34,711,484,359.83	100,314,974,473.23
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	81,656,977.00	12,358,662.00
1.1.4	Татаас, санхүүжилтийн орлого	-	42,505,576,979.22
1.1.6	Бусад мөнгөн орлого	27,471,419,016.28	28,595,360,376.27
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>40,195,203,076.84</b>	<b>141,833,748,595.79</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	19,284,046,022.94	31,977,953,685.09
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	5,622,422,521.78	9,030,473,354.22
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,758,737,581.80	5,738,086,040.36
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	1,966,744,457.02	3,310,189,200.89
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,296,540,466.37	10,305,117,489.29
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,952,672,936.57	9,466,023,437.39
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	48,832,612.00	258,653,727.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,994,462,610.05	71,747,251,661.55
1.2.10	Хүүний төлбөр төлсөн /ТӨҮГ/	270,743,868.31	-
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>22,069,357,276.27</b>	<b>29,594,521,894.93</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>103,344,587,548.89</b>	<b>931,082,534.34</b>
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,910,060,227.00	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	100,434,527,321.89	931,082,534.34
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>98,988,658,388.08</b>	<b>63,648,193,510.52</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,547,889,133.30	2,216,573,090.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	53,991,649.00	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	97,386,777,605.78	61,431,620,420.52
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>4,355,929,160.81</b>	<b>(62,717,110,976.18)</b>
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	<b>2,577,168,193.07</b>
	Бусад		2,577,168,193.07
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>2,577,168,193.07</b>
5	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>26,425,286,437.08</b>	<b>(30,545,420,888.18)</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>43,554,885,095.17</b>	<b>69,980,171,532.25</b>
7	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>69,980,171,532.25</b>	<b>39,434,750,644.07</b>

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөг/

д/д	Үзүүлэлт	2023 он	2024 оны			
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>Тээврийн үйл ажиллагаа /мян.тн/</b>	<b>1,965.1</b>	<b>6,000.0</b>	<b>4,156.8</b>	<b>1,843.2</b>	<b>69.3</b>
2	<b>Нийт орлого, санхүүжилт</b>	<b>42,857,166.6</b>	<b>170,794,114.3</b>	<b>127,534,352.9</b>	<b>43,259,761.4</b>	<b>74.7</b>
2.1	Цэвэр борлуулалт	32,990,626.6	156,834,615.8	95,144,528.1	61,690,087.7	60.7
2.2	Бусад орлого	9,892,804.7	5,498,340.3	32,389,824.8	(26,891,484.5)	589.1
2.2.1	Хүүгийн орлого	1,829,345.4	1,344,533.3	8,896,839.7	(7,552,306.5)	661.7
2.2.2	Бусад орлого	619,420.6	676,861.6	1,375,086.1	(698,224.5)	203.2
2.2.3	Скайтел антет	-	2,400.0	-	2,400.0	0.0
2.2.4	Түрээсийн орлого	7,444,038.7	3,474,545.5	22,117,899.0	(18,643,353.6)	636.6
3	<b>Төслийн санхүүжилт</b>	<b>17,877,384.3</b>	<b>8,461,158.2</b>	-	<b>8,461,158.2</b>	<b>0.0</b>
3.1	Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам төсөл	17,797,384.3	8,381,158.2	-	8,381,158.2	0.0
3.2	Холболтын төмөр зам төсөл	80,000.0	80,000.0	-	80,000.0	0.0
4	<b>Нийт зардал</b>	<b>41,260,967.5</b>	<b>163,161,241.6</b>	<b>81,999,155.3</b>	<b>81,162,086.2</b>	<b>50.3</b>
4.1	Борлуулалтын өртөг	40,108,057.3	135,825,805.0	67,056,077.1	68,769,727.9	49.4
4.1.1	Тээврийн үйл ажиллагаа	39,055,833.9	134,174,698.0	66,419,924.5	67,754,773.5	49.5
4.1.2	Төслийн үйл ажиллагаа /ТНАЛТ/	1,052,223.4	1,651,107.0	636,152.6	1,014,954.4	38.5
4.2	Ерөнхий удирдлагын зардал	1,152,910.2	1,540,397.6	10,293,769.6	(8,753,372.0)	668.3
5	<b>Захиалагчийн хяналтын зардал</b>	<b>17,270,621.6</b>	<b>25,795,039.0</b>	<b>4,649,310.4</b>	<b>21,145,728.6</b>	<b>18.0</b>
5.1	Тавантолгой-Гашуунсухайт төмөр зам төсөл	15,767,272.3	17,697,253.9	2,143,918.2	15,553,335.7	12.1
5.2	Холболтын төмөр зам төсөл	1,087,918.8	872,523.4	212,050.9	660,472.5	24.3
5.3	ТНАЛТ төсөл	-	1,068,617.5	1,219,292.5	(150,675.0)	114.1
5.4	Хил холболтын төмөр зам төсөл	415,430.5	6,156,644.3	1,074,048.7	5,082,595.6	17.4
6	Бусад зардал			15,289.3	(15,289.3)	100.0
7	<b>Хүү, татварын өмнөх ашиг</b>	<b>5,620,189.8</b>	<b>24,966,753.5</b>	<b>50,169,216.9</b>	<b>(25,202,465.2)</b>	<b>200.9</b>
8	<b>ОАТ-ын зардал</b>	<b>1,197,191.3</b>	<b>5,341,688.4</b>	<b>10,311,600.6</b>	<b>(4,969,912.2)</b>	<b>193.0</b>
9	<b>Цэвэр ашиг/алдагдал</b>	<b>4,422,998.5</b>	<b>19,625,065.1</b>	<b>39,857,616.3</b>	<b>(20,232,553.0)</b>	<b>203.1</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон санхүүгийн тайлагналтай холбоотой 6,316.1 сая төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулав.

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад эргэлтийн хөрөнгөнд тайлагнах байсан захиалагчийн хяналтын зардлыг дуусаагүй барилга гэж тайлагнасан	1	1,219,292.5	-	-	1	1,219,292.5	1
Захиргаа удирдлагын зарим ажилчдын цалин болон НДШ-ийн зардлыг төслийн өртөгт шингээх зорилгоор дуусаагүй үйлдвэрлэлийн зардалд бүртгэж, зардлын ангиллыг буруу илэрхийлсэн	1	3,076,831.0	-	-	1	3,076,831.0	1	3,076,831.0
Татварын зардлыг санхүүгийн орлого үр дүнгийн тайланд үнэн зөв тайлагнаагүй.	1	889,683.9	1	889,683.9	-	-	1	889,683.9
Хүүгийн авлага дутуу илэрхийлэгдсэн.	1	56,256.1	1	56,256.1	-	-	1	56,256.1
Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төслийн гүйцэтгэлд захиалагчийн хяналтын зардал нэмж бүртгэсэн	1	1,074,048.7	-	-	1	1,074,048.7	1	1,074,048.7
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>6,316,112.2</b>	<b>2</b>	<b>945,940.0</b>	<b>3</b>	<b>5,370,172.2</b>	<b>5</b>	<b>6,316,112.2</b>

3.2 Аудитаар нийт 77,045.3 сая төгрөгийн 19 зөрчил илэрснээс, нийт 14.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 74,236.8 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага, 2,794.1 сая төгрөгийн зөрчилд 8 зөвлөмж өгсөн.

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2024 оны 12 дугаар сард туршилтын хугацаагаар хөдөлмөрийн гэрээ байгуулсан 16 ажилтанд, хугацаатай хөдөлмөрийн гэрээтэй 4 ажилтанд улирлын үр дүнгийн урамшуулалт цалин олгосон.	1	14,439.0	1	14,439.0	-	-	-	-
Гүйцэтгэх захирлын тушаалаар нийт 50 сахилгын шийтгэлтэй ажилтанд улирлын үр дүн болон жилийн эцсийн урамшууллыг тус тус олгосон	1	290,349.3	-	-	1	290,349.3	-	-
Тус компанийн хөрөнгөнд бүртгэлтэй Гэрэгэ оффисын барилгыг МТЗ ТӨХК-д үнэ төлбөргүй ашиглуулж, улмаар уг хөрөнгөтөй холбоотой зардлыг тайлант хугацааны зардлаар бүртгэж тайлагнасан байна.	1	23,531.4	-	-	1	23,531.4	-	-
Компанийн зорилтот түвшний төлөвлөгөөг харгалзан үзэлгүй үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулж ажилласан гэсэн үндэслэлээр Тээврийн удирдлагын хэлтсийн ажилтнуудад жилийн эцсийн урамшууллыг олгосон	1	42,133.5	-	-	1	42,133.5	-	-
Компанийн хөрөнгийг бусдад үнэ төлбөргүй ашиглуулсанаар 2,800.0 сая төгрөгийн орлого олох боломжийг алдсан	1	2,800,000.0	-	-	1	2,800,000.0	-	-
ТУЗ-ийн шийдвэр гараагүйгээс төслийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй, хөрөнгийн хяналт сул	1	-	-	-	1	-	-	-
Газар эзэмших эрхийг нэгж бүрээр задалж бүртгээгүй. Нэг газар эзэмших эрх хүчингүй болсон	1	7,400,642.8	-	-	1	7,400,642.8	-	-
ЭТТ ХК-аас авах пүүний орлогыг тайлагнаагүй	1	475,400.0	-	-	-	-	1	475,400.0
Зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 6.0 сая тонн ачаа тээвэрлэхээс гүйцэтгэлээр 4.0 сая тонн ачааг тээвэрлэж ачаа тээврийн төлөвлөгөө 33 хувиар буюу 61,690.1 сая төгрөгөөр тасарсан.	1	61,690,100.0	-	-	1	61,690,100.0	-	-
Тайлант хугацааны эцэст нийт 768.0 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй	1	768,000.0	-	-	1	768,000.00	-	-
Тайлант хугацаанд хийгдсэн жилийн эцсийн тооллогод зөвхөн төв оффисын бараа материал, үндсэн хөрөнгийг хамруулан тоолсон ба орон нутагт байрлах кемпийн болон өртөөнүүдийн агуулахыг хамруулаагүй	1	-	-	-	1	-	-	-

Монголын төмөр зам ТӨХК, УБТЗ ХНН-тэй байгуулсан гэрээний дагуу төлбөрийг хугацаандаа төлөөгүй алдангийг нэхэмжилсэн боловч тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, төлүүлээгүй.	1	1,222,008.1	-	-	1	1,222,008.1	-	-
Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэлийг бодитоор төлөвлөж тайлагнаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-
Насжилт өндөртэй авлагад үнэ цэнийн бууралт тооцож, бодит үнэ цэнээр бүртгээгүй	1	810,546.1	-	-	-	-	1	810,546.1
Цаашид ашиглах боломжгүй болсон, гэмтэж хоцрогдолд орсон бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийг тооцоолж, тухайн барааны өртөгтэй харьцуулан үнэ цэнийг тогтоож үнэн зөв бүртгээгүй байна.	1	337,147.7	-	-	-	-	1	337,147.7
Шатахууны норм нормативыг тусгай зориулалтын машин механизмын шатахуун зарцуулалтын нормыг тусгайлсан журмаар зохицуулаагүйгээс Шатахууны зардлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй	1	-	-	-	-	-	1	-
Гэрээт ажилтан нэрээр батлагдсан орон тоог хэтрүүлэн ажиллуулсанаар цалингийн зардлыг батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлэн зарцуулсан	1	1,171,030.4	-	-	-	-	1	1,171,030.4
Орлого зардлыг зохицуулах НББ-ийн нийтээр хүлээн зөвшөөрсөн уялдаат зарим хангагдахгүй байх	1	-	-	-	-	-	1	-
Худалдан авалтыг хөрөнгийн нөөц, үлдэгдэлд харгалзахгүй төлөвлөх	1	-	-	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>19</b>	<b>77,045,328.3</b>	<b>1</b>	<b>14,439.0</b>	<b>10</b>	<b>74,236,765.1</b>	<b>8</b>	<b>2,794,124.2</b>

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн нийт 1 зөрчлөөс Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар 1 зөвлөмж өглөө.

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг ил тод байршуулж байх	1	-	-	-	1	-
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>